

## Баримт мэдээлэл

### Хугацаа:

2020-2027

### Дэмжин хэрэгжүүлэгч:

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар Ногоон Түүхий Эдийн Хөтөлбөр

### Санхүүжилтийн дэмжлэг:

Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн санхүүжилттэйгээр БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй “Монголын Унаган Байгалийн Хүлцэл, Тогтворжилтийг хангах нь” төсөл 2020 оны үйл ажиллагааг санхүүжүүлэв. Одоогоор 2 дахь жилийн (2021 оны) хамтарсан санхүүжилтийн хувилбаруудыг боловсруулж байна.

### Санхүүжилтийн хэмжээ:

2020 он – 306,450 ам.доллар

### Зорилтот болон оролцогч талууд:

- ➡ Малчид, малчдын бүлгүүд, хөдөө орон нутгийн иргэд, олон нийт
- ➡ Дотоодын болон Олон улсын хувийн секторын компаниуд
- ➡ Төрийн байгууллагууд, Үндэсний хэмжээний болон Орон нутгийн агентлагууд
- ➡ Хөгжлийн байгууллагууд, Олон улсын санхүүжүүлэгч байгууллагууд
- ➡ Иргэний Нийгмийн байгууллагууд

# МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ НООЛУУРЫН ПЛАТФОРМ



### ТОЙМ:

Монголын Тогтвортой Ноолуурын Платформ нь үндэсний хэмжээний хамтын манлайлын тулгуур тогтолцоо юм. МТНП нь ноолуурын салбарт тулгараад буй сорилтуудыг даван туулах системийн хэмжээний цогц стратегийг хэрэгжүүлэх ба

тогтвортой ноолуурын хамтын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхийн тулд өргөн цар хүрээг хамарсан бүх талын оролцогчидтой нягт хамтран ажиллана.

### ЗОРИЛГО:

- ➡ Монгол улсад ноолуурын тогтвортой үйлдвэрлэлийг хязгаарлаж буй үндсэн шалтгаануудыг арилгахад чиглэсэн “Талууд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжүүлэх;
- ➡ Төр засгийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар Монгол улсад “тогтвортой ноолуур”-ын бат бөх эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтыг бий болгох;
- ➡ Монгол улсад тогтвортой түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, ноолуур үйлдвэрлэлийг хөгжүүлэх одоогийн хүчин чармайлтуудыг хурдасгаж талуудын хооронд хамтын ажиллагаа, харилцан уялдаатай хөрөнгө оруулалт, нэгдсэн арга хэмжээг бий болгох;
- ➡ Монгол улсыг “тогтвортой ноолуур”-ын тэргүүлэгч үйлдвэрлэгч орон болгох.

### ҮНДЭСЛЭЛ:

Хөгжиж буй олон улс орнуудын адил Монгол улс эдийн засгийн хөгжлийн асуудлыг хүрээлэн буй орчны доройтол, байгалийн нөөцийн хомсдлын асуудалтай хамт тэнцвэржүүлэн авч үзэх нь томоохон сорилт болоод байна. Нөгөө талаас мал аж ахуйн салбар манай улсын нийт хөдөө аж ахуйн

гаралтай бараа бүтээгдэхүүний 80 гаруй хувийг бүрдүүлэхийн зэрэгцээ нийт ажиллах хүчний 30 орчим хувийг хамарч байна. Тэр дундаа ноолуур бол Монгол улсын стратегийн түүхий эд бөгөөд нэг сая орчим бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй малчдын амьдралыг тэтгэж байгаа эдийн засгийн

чухал тулгуур салбар юм. Дэлхий дахинд байгалийн цэвэр ширхэгт, тансаг зэрэглэлийн ноолууран бүтээгдэхүүний их хэмжээний эрэлт бий болсноор ноолуурын эрэлтийг бүхэлд нь огцом ихээр өсгөв.

Улмаар ямааны тоо толгой Монгол улсад өнгөрсөн хорин жилийн турш 7 саяаас 27 сая болтол эрчимтэй нэмэгдэхийн зэрэгцээ манай улс дэлхийд ноолуурын хоёр дахь томоохон нийлүүлэгч орон болов. Энэ хэрээр бэлчээрийн даац хэтэрч, ой мод устаж, бэлчээр, хөрсний элэгдэл зэргээс байгаль орчны доройтол бий болж биологийн олон янз байдал алдагдахад хүрч байна. Малчдын хувьд устан доройтож буй бэлчээрийн асуудалтай нүүр тулж, ойлгож хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ мал маллагааны өдөр тутмын хэвшилдээ өөрчлөлт оруулж урьд өмнө нь яригдаж байгаагүй тогтвортой мал маллагаа, үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэлийн арга аргачлалд шилжиж байна. Үндэсний хэмжээний боловсруулах үйлдвэрүүд ч мөн адил энэ жишгээр өөрчлөгдсөөр байна.

Гэсэн хэдий ч малчдын нүүдэллэх хэв маяг, дундын зуучлагчийн оролцоо, худалдаачдаар дамжин хийгдэж буй ноос, ноолуурын арилжаа зэрэг нь малын мөрдөн мөшгих тогтолцоо, нийгмийн болон байгаль орчны үнэлгээ, хяналтыг хүндрэлтэй болгож байна. Улмаар Монгол улс тогтвортой

ноолуурын эх үүсвэр байж чадах эсэх тухай асуудлыг ч хөнддөг. Энэ бүхний цаана том зургаар тодорхойлбол “тогтвортой бэлчээрийн менежмент” үндэсний хэмжээний урт хугацааны нийгэм эдийн засгийн тогтвортой байдал, хүлцэл тогтворжилтыг хангах юм. Маш олон иргэний нийгмийн байгууллага, төсөл хөтөлбөрүүд “Тогтвортой ноолуур”-ын эргэн тойронд тулгарч буй асуудлыг шийдэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төслүүд ялгаатай аргачлал, нөлөөллийн үнэлгээний өөр өөр арга замуудыг ашиглаж байна.

Энэ байдал нь ноолуур худалдан авагч томоохон брэндүүдийн хувьд аль нь гарал үүсэл баталгаатай бөгөөд “тогтвортой” байдлын шаардлагуудад нийцэхүйц, итгэлтэйгээр дагаж мөрдөж болохуйц хамгийн шилдэг аргачлал вэ гэдгийг магадлахад хүндрэлтэй болгож байна.

Тиймээс НҮБХХ-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар нь НҮБХХ-ийн Ногоон Түүхий эдийн Хөтөлбөрийн туслалцаатайгаар ноолуурын салбарт тогтвортой хэмжүүрийг танилцуулах хэрэгцээ шаардлага байгааг олж харсны үндсэн дээр Монгол улсыг дэлхийд тогтвортой ноолуурын тэргүүлэгч орон болгох зорилго тавин Тогтвортой Ноолуурын Платформыг бий болголоо.



## ҮЕ ШАТ БОЛОН ЧУХАЛ МӨЧЛӨГҮҮД



## ПЛАТФОРМЫН БҮТЭЦ ЗАСАГЛАЛ



### Холбоо барих:

Монголын Тогтвортой Ноолуурын Платформ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын гудамж 14, Сүхбаатар дүүрэг, 14201, Улаанбаатар, Монгол Улс

### Утас:

+976-11-327585  
+976-99030873; 99023005

### Имэйл:

shinenemekh.voloog@undp.org;  
odgerel.oyungerel@undp.org

### Вэб хуудас:

www.mn.undp.org  
www.sustainablecashmereplatform.com